VII

БАТЛАВ:
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАДАМСҮРЭН

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 6 ДУГААР БАГ "БУЙР ХОРООЛОЛ"-ЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: ДЗД/23-07

2023.02.10

Чойбалсан хот

1	Боловсруулах үндэслэл	- Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.1 дэх заалт - Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 10.1.1 дэх заалт - Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын 2030 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө - Дорнод аймгийн Засаг даргын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.2.1 дэх заалт (Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Ивээл, Буйр хороллын хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулж, дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлнэ)
2	Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал	- Дорнод аймаг нь нийслэл Улаанбаатар хотоос 665 км зайд алслагдсан, геополитикийн хувьд МУ-ын зүүн хязгаарт ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол аймгуудтай хил залгадаг, томоохон хотуудтай хамтын ажиллагаатай, газар нутгийн хувьд 123,7 км² газар нутагтай, Дорнод аймаг нь 85.3 мянган хүн амтайгаас Чойбалсан хотын 28024 га газар нутагт 48089 хүн оршин суудаг улсын хэмжээнд хүн амын нягтралын хувьд Монгол улсын 4 дэх том хот юм. Хэнтий нурууны салбар уулсын төгсгөл, тал хээрийн бүсэд байрладаг, уур амьсгал, газар зүй, байгалийн тогтоцын хувьд харьцангуй таатай байршилтай. - Улсын Их Хурлын 2003 оны 01 тоот тогтоолоор Монгол улсын эдийн засгийн үндсэн бүсүүдийн хүрээнд нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах чиг үүрэгтэйгээр Дорнод аймгийг зүүн бүсийн тулгуур төв байхаар шийдвэрлэсэн. - ОХУ-тай Ульхан, Эрээнцав, БНХАУ-тай Хавирга, Баянхошуу, Нөмрөг, агаарын зэрэг хилийн 6 боомттой. - Зүүн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах ДБЭХС ТӨХК-тай, тус компани нь Чойбалсан хотын цахилгаан, дулааныг бүрэн хангадаг. - Үйлдвэржилт хөгжсөн, байгалийн нөөц, ашигт малтмал ихтэй. - Буйр хороолол нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар багт байрладаг бөгөөд тус хорооololд 68 өрх, 350 хүн ам, 28 иргэн, аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулдаг.
3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (м2)	- Хэрлэн сум, 6 дугаар баг, Буйр хороолол нь баруун талаараа Худалдаачдын гудамж /Шүр зах/, хойд талаараа "Шинэ хөгжил" цогцолбор сургууль, цэцэрлэг, орон сууцны "Ургах наран", "Уурхайчин" хороолол, зүүн талаараа

		"ДБЭХС" ТӨХК, урд талаараа Чойбалсангийн гудамжаар хүрээлэгдсэн нийт 30 га талбайг хамаарна. (Талбайн зураг хавсралтаар өгөв) - Төлөвлөлтийн хязгаарын эргэн тойронд байрлах барилга байгууламж, авто замтай уялдуулах.
4	Боловсруулах ажлын үе шат	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нийт хугацаа 150 хоног байна. (Магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэх хугацаа ороогүй болно). Үүнээс: - **Эхлэлийн тайлан:** (60 хоногт гүйцэтгэнэ/ - Одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглал, инженер геологийн судалгаа дуусан байх. Тухайн хэсгийн одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, судалгааны түвшинд хувилбар дэвшүүлж төлөвлөлтийг боловсруулах; - Иргэд, оршин суугчдаас олон нийтийн санал авах /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санал авах/ - **Дундын тайлан:** /60 хоногт гүйцэтгэнэ/ - Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу газар зохион байгуулалт, бүсчлэлийн төлөвлөлт, авто зам, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх; - Төлөвлөлтийн эхний хувилбарыг боловсруулж инженерийн шугам сүлжээний хангагч болон мэргэжлийн байгууллагуудад танилцуулж санал авах; - Төлөвлөлтийн эхний хувилбарыг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэг хийх /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/ - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах; - **Эцсийн тайлан:** /30 хоногт гүйцэтгэнэ/ - Орон нутгийн захиргааны байгууллагуудын холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлэх; - Улсын экспертизийн дүгнэлт гаргуулах; Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;
5	Боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд** - Хот байгуулалтын тухай хууль, - Барилгын тухай хууль, - Газрын тухай хууль, - Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, - Усны тухай хууль, - Орон сууцны тухай хууль, - Геодези зураг зүйн тухай хууль, - Эрчим хүчний тухай хууль, - Харилцаа, холбооны тухай хууль, - Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, - Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журмууд

		Бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд; - Монгол Улсын Тогтвортой хөгжлийн бодлого-2030, - Гурван тулгуурт хөгжлийн бодлого, - Зүүн бүсийн тулгаар төв, Дорнод аймаг, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. 2030 он, **Норм, норматив, стандарт** - Хот,тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04), - Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам, - Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 11-202-00), - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм (БХБ-ын сайдын 2019 оны 54-р тушаал), - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00);, - Барилга байгууламжийн инженер экологийн судалгаа (БД 11-102-07), - Зураг төслийн ажлын жишиг үнэ (БХБЯ 2020 он БД 81-16-20), - Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам (ЗТБХБ-ын сайдын 183-р тушаал), - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахдаа 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ын масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил (БД 11-106-08), - Инженерийн шугам сүлжээний зургийн ажил (БД 11-105-06), - Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНбД-32-01-04), - Авто зогсоол (БНбД 21-05-10), - Геодезийн байгчын цэг тэмдэгт байгуулах ажил (БД 11-104-06), - Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ MNS 5873:2008, - Ландшафтын зураг боловсруулах MNS ISO 11091:2007, - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6055:2009, - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам MNS 6056:2009, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт MNS 5682-2006 - Бусад холбогдох норматив баримт бичиг, стандартууд **Судалгааны материалууд:** - Барилга, байгууламжийн инженер экологийн судалгаа (БД 11-102-07), - Дорнод аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой судалгааны материал, - Газрын зураглал /геодези, байрзүйн зураг/, - Геоморфологийн судалгаа,

		- Урьд хийгдсэн хөрсний болон усны хайгуулын судалгааны материал, - Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлийн аюулын үнэлгээний тайлан, - Дорнод аймгийн газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох төслийн тайлан, - Дорнод аймгийн газар хөдлөлийн бичил мужлалын судалгаа, - Дорнод аймгийн аялал жуулчлалын үндсэн маршрутыг хөгжүүлэх төлөвлөгөө, - Бусад материалууд
6	Баримт бичгийн бүрдэл,	**1.Төлөвлөлтийн ажлын суурь судалгаа** - Инженер-геологийн судалгаа - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ - Судалгааны материал /иргэд оршин суугч, аж ахуй нэгж, төлөвлөлтийн бүсэд хийсэн судалгаа зэрэг бусад шаардлагатай материал/. **2.Тайлбар бичиг**: Дараах асуудлуудыг судалгаа, тооцоонд тулгуурлан тодорхой тусгасан байна. Үүнд: Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ /хороллын хэмжээнд/ харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо; - Төлөвлөлтийн үндсэн шийдэл боловсруулах - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ээлж дараалал; - Эхний ээлжинд хэрэгжүүлэх инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээ, байгаль хамгаалалд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, хэрэгжүүлэх арга хэмжээ; - Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт; - Барилгажих арга хэмжээ, ээлж дараалал; - Техникийн нөхцөлүүд; - Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, эдийн засгийн тооцоо - Бүтээн байгуулалтын ажлын график төлөвлөгөө - Төлөвлөлтийн концепц, хувилбар - Хөрөнгө оруулалт үр ашгийн тооцоо - Төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоо - Зардлын тооцоолол ангилал - Хөрөнгө оруулалт үр өгөөж - Санхүүжилтийн төлөвлөгөө - Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагны бизнес төлөвлөгөө /төслийн менежмент/ **3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө** Хот төлөвлөлтийн суурь судалгаанд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах. <u>*Судалгаа одоогийн байдал*</u> - Байршилын схем М1:25000; - Орчны тойм М1:10000 - Дэвсгэр зураг М1:5000

		- Төрийн үйлчилгээ, олон нийтийн үйлчилгээний барилгын төлөвлөлт, хамрах хүрээ М1:2000 - Орон сууцны хангамж М1:2000 - Өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн төрөл, хүчтн чадал, хамрах хүрээ М1:5000 - Дулаан хангамж М1:2000 - Усан хангамж, ариутгах татуурга М1:2000 - Цахилгаан хангамж М1:2000 - Холбоожуулалт М1:2000 - Нийгмийн дэд бүтэц, үйлчлэх хүрээ М1:5000 - Инженерийн бэлтгэл арга хэмжээ өндөржилт, улаан шугам М1:2000 - Үерийн хамгаалалт, далангийн зураг М1:5000 - Авто зам, тээврийн сүлжээ М1:5000 - Ногоон байгууламж, явган хүний зам, спорт талбай, амрах бүс М1:2000 - Газар зохион байгуулалтын бүсчлэл М1:2000 - Газар ашиглалтын талбайн баланс М1.5000 - Түүх соёл, аялал жуулчлал болон бусад онцгой барилга байгууламжуудын байршил үйлчлэх хүрээ М1:5000 - Гамшгийн менежмент М1:5000 <u>*Архитектур орон зайн төлөвлөлт:*</u> - Байршилын схем М1:25000; - Орчны тойм М1:10000 - Гудамж зам, тээврийн сүлжээ М1:2000; - Газар нутгийн үүргийн зориулалт, бүсчлэл М1:2000 - Ногоон байгууламж, задгай орон зайн төлөвлөлт М1:2000 - Ерөнхий төлөвлөгөө /зураглалаар ялгасан/ М1:2000/ - Ерөнхий төлөвлөгөө М1:1000 - Хөдөлгөөний схем М1:2000 - Гол гудамжны дэлгээс М1:500 - Дахин төлөвлөлтийн орон зайн төлөвлөлт, үе шат М1:2000 - Эхний ээлжийн барилгажилт, дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт М1:1000 <u>*Нийгмийн хангамжийн төлөвлөлт:*</u> - Засаг захиргааны барилга байгууламжМ1:2000 - Үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж М1:2000 - Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж М1:2000 - Эмнэлэг, эмийн сан, онцгой байдлын барилга байгууламж М1:2000 - Спорт биеийн тамирын барилга байгууламж М1:2000 - Жижиг дунд үйлдвэрийн барилга байгууламж М1:2000 - Түүхэн дурсгалт барилга байгууламж М1:2000 <u>*Газар зохион байгуулалт:*</u> - Газар зохион байгуулалтын төлөвлөгөө М1:2000

		- Нүүлгэн шилжүүлэх эдэлбэр газрын судалгаа М1:2000 - Газар шинэчлэн зохион байгуулах схем М1:2000 - Төлөвлөлтийн үе шат М1:2000 *<u>Зам тээврийн сүлжээний төлөвлөлт:</u>* - Авто замын төлөвлөлтийн зураг М1:2000 - Авто замын өндөржилт, улаан шугам М1:2000 - Авто замын огтлол М1:200 - Нийтийн тээврийн төлөвлөлт М1:2000 - Дугуйн замын төлөвлөлт М1:2000 - Явган замын төлөвлөлт М1:2000 *<u>Инженерийн хангамжийн төлөвлөлт:</u>* - Инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт М1:2000 - Инженерийн бэлтгэл арга хэмжээ М1:2000 - Өндөржилт М1:200 - Дулаан хангамжийн төлөвлөлт М1:2000 - Цэвэр ус, ариутгах татуургын төлөвлөлт М1:2000 - Цахилгаан хангамжийн төлөвлөлт М1:2000 - Мэдээлэл, холбоо шугам сүлжээний төлөвлөлт М1:2000 - Хог хаягдлын менежментийн төлөвлөлт М1:5000 *<u>Харагдах байдал 3 хэмжээст:</u>* - Ерөнхий харагдах байдал /6-аас доошгүй/ - Гол гудамж зам талбайн харагдах байдал /төлөвлөлтөд хамрагдсан хорооллын чанартай замын дагуу/ - Орон сууцны хорооллын харагдах байдал /4-өөс доошгүй/ - Амралт зугаалга, задгай орон зайн харагдах байдал /4-өөс доошгүй/ - Нийгмийн хангамжийн барилга байгууламж орчмын харагдах байдал /2-оос доошгүй/ - Худалдаа, үйлчилгээний бүсийн харагдах байдал /4-өөс доошгүй/ - Газар шинэчлэн зохион байгуулалт хийгдсэн байршлуудыг /4-өөс доошгүй/ *<u>Хөдөлгөөн дүрслэл (анимэйшн):</u>* - Харагдах байршилд дурдсан байршлуудыг хамруулах *<u>Макет:</u>* - Гэрэлтүүлэг, өнгө үзэмжтэй сайтай байна. *<u>Зураг төсөлд тавигдах шаардлага</u>* - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага /Хавсралт 3-ын дагуу хийх/
7	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	***Төсөл хэрэгжүүлэх талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа:*** - Төсөл хэрэгжүүлэх талбайн хэмжээнд судалгаа явуулсны үндсэн дээр тэнд байрлаж буй гэр хорооллын айл өрхүүд болон худалдаа үйлчилгээний зориулалтай барилга байгууламжуудыг эмхэлж цэгцлэн зохион байгуулалтад оруулах

		- Нутаг дэвсгэрийн онцлог, үнэмлэхүй давуу ба сул талууд, сөрөг нөлөөллүүдийн судалгаа, дүгнэлт хийх; - Суурь судалгаа, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр төвийн байршил, эдэлбэр газрын хэмжээг нарийвчлан тодорхойлох; - Байгаль экологийн, нийгэм эдийн засгийн, хот байгуулалт, архитектур орон зайн төлөвлөлт-ландшафтын хүчин зүйлийн иж бүрэн үнэлгээ хийсний үндсэн дээр хүн амын нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн барилгажилт, тохижилт бүхий архитектур орон зайн зохистой бүтэц, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх; - Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын уялдааг хангах; - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан, нутаг дэвсгэрийн газар ашиглалтын зонхилох зориулалтыг нарийвчлан тогтоож, хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу, газар ашиглалтыг дээд зэргийн үр ашигтай байхаар дараах бүсүүдэд ангилан, төлөвлөлтийн шийдлийг боловсруулах; - Тухайн нутаг дэвсгэр болон шинээр төлөвлөгдсөн 1000 айлын орон сууцны хороолол, байгаль, цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм, эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, тохижилт бүхий орон зайн бүтэцтэй хот төлөвлөлт, архитектурын онцлог шийдлийг гаргах; - Олон нийт, соёл, үйлчилгээний төв нь барилгажилтын хувьд харилцан уялдаа сайтай, орон зайн харьцаа, архитектур төлөвлөлтийн хувьд цогцолбор байх чиглэлийг баримтлах; - Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт амралт зугаалгын бүс, авто зогсоолын талбай, нөөц талбайг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Бүсийн бүтээн байгуулалтанд болон хэвийн орчинд нөхөн сэргээгдэх эрчим хүч, хүн болон байгальд ээлтэй арга, технологуудыг аль болох өргөнөөр хэрэглэх бололцоог хангах (барилгыг нарны тусгал ихтэй байхаар байршуулах); - Борооны ус, саарал усыг дахин ашиглах шинэ техник, технологийн оновчтой шийдлийг төлөвлөлтөнд тусгах; - Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх гамшигийн үед авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд эрсдэлгүй газарт биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж зэрэг барилгажилт багатай бүсийг аль болох төлөвлөх зарчмыг баримтлах; - Инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг иж бүрэн оновчтой шийднэ. - “Ногоон, ухаалаг хот”-ыг байгуулж, хөгжүүлэх үзэл баримтлалын дагуу төлөвлөлтийн үндсэн шийдлийг боловсруулна. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгоход хот байгуулалтын талаас шаардлагатай арга хэмжээг төлөвлөлтөд тусгана.

		Өндөржилт, улаан шугам: - Талбайн өндөржилтийн төлөвлөлтийг боловсруулахдаа: ▪ Гадаргуугийн усыг хөрсний эвдрэлд нөлөөлөхгүйгээр зайлуулах нөхцөлийг тооцно. ***Зам, тээврийн сүлжээ:*** - Төсөл хэрэгжүүлэх талбайн гудамж, зам тээврийн сүлжээг эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх зарчмаар төлөвлөх; - Зам /авто замын бүх төрөл, унадаг дугуй, явган зам, авто зогсоолын бүх төрөл г.м/, тээврийн хөдөлгөөний болон тээвэрлэлтийн эрэлт, нийлүүлэлт, авто машины зогсоолын хангамжийн судалгаа, үнэлгээ дүгнэлтийг хийнэ. - Төсөл хэрэгжүүлэх талбайн гадна ба доторхи гудамж, замын сүлжээг нэгдсэн систем байхаар төлөвлөнө. Төлөвлөлтийг боловсруулахдаа хотын орон зайн тогтолцоо, хүн амын өсөлт, дугуйтай болон явган зорчигч, тээврийн хөдөлгөөний эрчим, тэдгээрийн байнга өсөн тэлж байх явцтай уялдуулна. - Гудамж, замын сүлжээний төлөвлөлтийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, иргэд богино хугацаанд тохь тухтай зорчих шаардлагад нийцүүлсэн байна. - Гол гудамж, замыг хотын ирээдүйн хөгжилтэй уялдуулан цаашид өргөтгөх, нийтийн тээврийн хэрэгслэлийг голлон ашиглах боломжтой байдлаар тооцож, төлөвлөнө. ***Ногоон байгууламж:*** - Цэцэрлэгжүүлэлтийг төсөл хэрэгжүүлэх талбайн хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг хангасан, орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчинг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалсан, баригдах барилга байгууламжуудын архитектур-орон зайн зохиомжид сайн нөлөө үзүүлэхээр тооцож төлөвлөнө. - Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хөрөнгө оруулалтын ойролцоо тооцоог гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулах;
8	Инженерийн бэлтгэл арга хэмжээ	- Инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалтын болон хөрсний ус зайлуулах арга хэмжээг эдэлбэр газрын хэмжээнд иж бүрэн төлөвлөх, гадаргуугийн болон хөрсний усыг цуглуулан усан сан байгуулах, ногоон байгууламжийн усалгаанд эргүүлж ашиглах талаар газар зохион байгуулалт, ашиглалтын байдлаас хамааруулан төлөвлөнө. - Төсөл хэрэгжүүлэх талбайн төлөвлөлтийг боловсруулахдаа гадаргуугийн усыг зайлуулах инженерийн барилга байгууламжийг тусгана.
9	Инженерийн дэд бүтцийн хангамж, ах үүсвэр	*Дулаан хангамж:* Техникийн нөхцлийн дагуу - Эхний ээлжинд одоо байгаа дулааны эх үүсвэрээс хангагдах, эх үүсвэрийг өргөтгөх боломжийг харгалзан

		судлах, төлөвлөлтийн хугацаанд халаалтын нэгдсэн эх үүсвэрээс хангагдахаар төлөвлөх, хог хаягдал болон байгальд ээлтэй бусад технологуудыг дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэлд санал болгох; *Ус хангамж:* Техникийн нөхцлийн дагуу - Усны хайгуулын судалгаанд тулгуурлан эх үүсвэрийн нөөцийг тогтоож, төвлөрсөн усан хангамжид холбогдохоор төлөвлөх. *Ариутгах татуурга:* Техникийн нөхцлийн дагуу - Төлөвлөж буй бүсийн барилга байгууламжийн ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологийн дагуу төлөвлөх (мембраны болон центрфугийн гэх мэт); *Цахилгаан хангамж:* Техникийн нөхцлийн дагуу - Төвийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг тодорхойлон, ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх (Нарны нөхөн сэргээгдэх эрчим хүчний том хүчин чадалтай цахилгаан станцуудын өртөг зардал хямд байгааг төлөвлөлтөд харгалзах); *Холбоо мэдээлэл:* Техникийн нөхцлийн дагуу - Мэдээлэл холбооны өндөр хурдны сүлжээнд холбохоор төлөвлөх; Инженерийн хангамжийг техникийн шийдэл, өгөгдсөн техникийн нөхцлийн дагуу эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн технологитой байхаар төлөвлөх, гудамжны гэрэлтүүлэгт сэргээгдэх эрчим хүч (нар, салхи)-ийг ашиглах боломжийн талаар тусгах;
10	Нийгмийн дэд бүтцийн хангамж	- Барилга байгууламжийн хангамж, хэрэгцээг өнөөгийн болон хэтийн эрэлт, нийлүүлэлтийн харьцаанд үндэслэн тооцох - Аялал жуулчлалын бүсийн барилга байгууламжийг хотын архитектур-орон зайн зохиомж, дүр төрх, орчинтой нь уялдуулан төлөвлөх. - Худалдаа үйлчилгээний барилга байгууламжын тодорхой хувийг зорилтот бүлгийн иргэдэд зориулан түрээсийн болон төлбөрийн чадварт нийцсэн буюу холимог байхаар уялдуулан төлөвлөх.
11	Орон сууцны хангамж	- Зүүн бүсийн тулгаар төв, Дорнод аймаг, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт заасан тухайн бүсийн хамаарагдах хороолол, хүн амын нягтрал, орон сууцны дундаж давхар зэргийг баримтлан төлөвлөх.
12	Төслийн онцгой нөхцөл	- Болзошгүй гамшгийн үед авах арга хэмжээг төлөвлөлтөд тусгах. Үүнд: - Гамшгийн үед хороллын иргэдийн цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх зам гарц тодорхой ойлгомжтой байх. - Гал унтраах машин тоног төхөөрөмжүүдийн ажиллах зай талбайг норм дүрмийн дагуу төлөвлөх - Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг авто замын төлөвлөлттэй хамт шийдвэрлэх - Байгаль орчныг хамгаалах, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах технологийн талаар тусгах

		- Шаардлагатай хэсгүүдэд орон сууцны барилга төлөвлөх - Төмөр зам, авто замын мастер төлөвлөгөө, одоо хийгдсэн болон төлөвлөгдөж буй дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөх; - Одоо байгаа барилгажсан хэсэгтэй уялдуулах; - Шинээр төлөвлөгдөж байгаа аялал жуулчлалын бүсийн зам тээврийн сүлжээг олон улсын туршлагыг харгалзан төлөвлөж, цаашид ачаалахгүй байх нөхцөлийг хангахаар тусгах; - Авто зам, явган зам, талбай, хичээлийн байр, бусад зориулалтын барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих нөхцөлөөр хангагдсан байх; - Байгаль-экологийн хувьд хөрс, ус, агаарын бохирдолгүй орчныг бүрдүүлж, менежментийн оновчтой шийдлийг төлөвлөлтөд тусгах, голын эрэг, далангийн бэхлэлт, хамгаалалт, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх; - Техник, технологийн оновчтой шийдэл бүхий эдийн засгийн өндөр үр ашигтай, орчин үеийн технологитой, байгаль орчинд ээлтэй байх төлөвлөлтийн шийдлийг дэвшүүлэх; - Хог хаягдлын дэвшилтэд менежментийн саналыг тусгах - Шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зайг баримтлах; - Ундны болон ахуйн хэрэгцээний усны асуудлыг онцгой судлан, шийдлийг гаргах; - Инженерийн хэсэгчилсэн хангамжийн төлөвлөлт, харьцуулалт, эдийн засгийн үр ашгийг тооцож, оновчтой хувилбарыг сонгох; - Орчин үеийн шинэ дэвшилтэт, техник технологийн шийдэл бүхий цэвэрлэх байгууламж, эрчим хүчний бие даасан системийг судлан төлөвлөлтөд тусгах; - Сэргээгдэх эрчим хүч, хийн хангамжийн шийдлүүдийг тусгах, эдийн засгийн үр ашгийг тооцох; - "Хот байгуулалтын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 болон 17.2 дахь заалтын дагуу хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахтай холбогдуулан, ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн шийдлийг төслийн шатанд холбогдох яам, агентлаг, мэргэжлийн байгууллагуудад танилцуулан, оновчтой саналыг тусгах, орон нутгийн удирдлагуудтай зөвшилцөх. - Зураг төсөлд тодорхой ишлэл авсан техникийн баримт бичгийг тодорхой заах, холбогдох тооцоо, судалгааг тайлбарт нарийвчлан тусгах;
13	Боловсруулах хугацаа	- Гэрээ байгуулсан өдрөөс хойш 150 хоног
14	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө (60,0 сая төгрөг)

15	Захиалагч байгууллага	Аймгийн Засаг даргын Тамгын газар
16	Гүйцэтгэгч байгууллага	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх.
17	Зөвшөөрөлцөх байгууллага	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар Инженерийн шугам сүлжээний хангагч байгууллага

ТАНИЛЦСАН:

ДОРНОД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА — М.НЯМСҮРЭН

ХЯНАСАН:

ДОРНОД АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР — А.ТҮМЭНЖАРГАЛ

ДОРНОД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — М.АРЪЯАЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:

ДОРНОД АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР, ЗУРАГ, ТӨСӨВ, МАГАДЛАЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Б.БАТХҮҮ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙН БАЙРШИЛ 30,0 ГА



СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ, ТООЦООЛЛЫН ҮЕ ШАТАНДТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий нэр	Нарийвчилсан нэр	Судалгааны агуулга
Байгаль орчин	Газарзүйн байршил	Газар зүйн байршлын онцлог, өндөржилт, налуужилт
	Инженер геологи	Ус, ургамал, хөрс, чулуулаг, цэвдэг
	Ус ашиглалт, усны хаалт, усны чанар	Усны шинжилгээ, гол горхи тус бүрийн усны хэмжээ, үерийн үед усны халилтын хязгаар
	Уур амьсгал	Агаарын температур, хур тунадасны хэмжээ, нарны гэрэл /ээлт/, салхины чиглэл, салхины хурд, манангийн уналт /сард хэд/
	Үер усны гамшгийн баримтууд, дахин давтагдах эсэх	Өнгөрсөн 20 жилийн хугацаанд гарсан үерийн баримт, Үерийн усны барилга байгууламж, ашиглалтын байдал /Мэдээллийн бааз үүсгэх/
	Газар хөдлөлтийн мэдээлэл, дахин давтагдах магадлал	Өнгөрсөн 20 жилийн хугацаанд гарсан газар хөдлөлтийн баримт, хагралт, цуурал Мэдээллийн бааз үүсгэх/
Нийгмийн дэд бүтэц	Засаг захиргаа	Засаг захиргаа, төрийн байгууллагуудын бүтэц, байршил, үйлчлэх хүрээ, хүчин чадал хүрэлцээ
	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг	Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хамрах хүрээ, хүчин чадал,хүрэлцээ
	Зориулалт тус бүрийн талбай	Олон нийтийн барилга
Газар ашиглалт	Газар ашиглалтын бүсчлэл	Эдэлбэр газрыг ашиглалтын төрлөөр нь судлан гаргаж, одоогийн газар ашиглалтын бүсчлэл гаргах
	Газар ашиглалтын талбайн баланс	Газар ашиглалтын талбайн балансийг гаргах
	Газар ашиглалтын эрхийн хэлбэр	- Газар өмчлөх, эзэмших, ашиглах хэлбэрээр нь ангилан харуулах - Газрыг төрийн, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлээр ялган харуулах
	Газар ашиглалтын төрөл	Одоо байгаа газар ашиглалтыг төрлөөр нь ялган харуулах /орон сууц, олон нийтийн, үйлчилгээ, ногоон байгууламж, зам талбай, инженерийн дэд бүтэц, хамгаалалтын зурвасууд г.м/
	Газрын үнэ	Газрын үнэ /байршил бүрээр харьцуулах/ нэрлэсэн үнэ ба дуудсан үнэ
	Зах зээлийн чиг хандлага	Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хэрэглээний хүрээний тэлэлт, талбайн өөрчлөлтийн байдал
	GIS дээр үүсгэсэн мэдээлэл	Эдэлбэр газар тус бүрээр мэдээлэл үүсгэх /газрын байршил, газар эзэмшигчын нэр, эдэлбэр газрын дугаар, талбай, газрын захирамжын дугаар/
	Гамшгийн аюулийн хүчин зүйлс	Гамшгийн аюулд өртөх магадлалтай бүсийг тодорхойлох
Хүн ам	Хүн амын тооны өөрчлөлт	Олон жилийн дундаж хугацааны хүн амын хөдөлгөөн
	Хүн амын нягтаршил	Төлөвлөгдөж буй байршил дээрх нийт хүн ам болон, газар нутаг болгоны /хороо, дүүрэг/ хүн амын нягтаршил болон суурин болон түр суурьшиж буй иргэдийн тоог тодорхойлох;
	Хүн амын бүрдэл	Нас, хүйс, өндөр настан, нярай, цэцэрлэг, сургуулийн насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тус бүрээр гаргах
	Хүн амын өдөр шөнийн идэвхжил	Өдрийн цагаар идэвхтэй амьдралтай, идэвхгүй амьдралтай хүн амын ялгаа

	Хүн амын ажил эрхлэлт	Аж үйлдвэр тус бүрийн хүн ам, гол, онцгой аж үйлдвэрийн хүн амын ажлын ерөнхий байдал, ажлын төрөл бүрээр нь хүн амын тоо, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын нас
	Өрх	Өрхийн тооны өөрчлөлт, жирийн өрх, ганц бие өрх
	Хүн амын хөдөлгөөний байдал	Шилжин ирэгсдийн өнөөгийн байдал, өөрчлөлтийн байдлыг тодорхойлох
Байр, орон сууц	Орон сууцны тоо	Орон сууцны төрөл бүрээр, хэмжээ бүрээр, байрны тоо
	Орон сууцны хүрэлцээ	Хувийн орон сууцгүй өрх, орон сууцны хүрэлцээний хувийн өөрчлөлт
	Орон сууцны багтаамж	Орон сууцны дундаж хэмжээ, нэг хүнд ногдох байрны талбай
	Хөлсний байр	Хөлсний байр тус бүрийн тоо, үйл ажиллагааны төлөвлөгөө
	Байр, орон сууцны хангамж	Шинэчилсэн барилга, шинээр барилгажилт, орон сууцны орчин нөхцлийг сайжруулах ажил зэргийн үйл ажиллагааны зорилго, хангах хэмжээ
Эдийн засаг	Аж үйлдвэр	Аж үйлдвэр тус бүрийн жилийн дундаж орлого, бизнесийн цар хүрээ, ажилчдын тоо
	Аялал жуулчлал	Тосгоны тэргүүлэх чиглэлийн аялал жуулчлал
	Эдийн засгийн хөдөлгөөнт хүн ам	Эдийн засгийн идэвхтэй хүн амаар тодорхойлох, ажиллах хүчний судалгаа
	Аж ахуй нэгж байгууллага	Тосгоны аж ахуй нэгж байгууллагын тоо, ажилчдын тоо
	Эдийн засгийн тооцоо	Нүүлгэн шилжүүлэх шаардлагатай нэгж талбарын одоогийн байдлын үнэлнээ,нүүлгэн шилжүүлэх зардлыг тооцох
	Үл хөдлөх хөрөнгө	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын газар дээрх өмчлөл, эзэмшил бүхий үл хөдлөх хөрөнгийн жагсаалт, одоогийн зах зээлийн үнэлгээг томсгосон байдлаар тооцоолж гаргах
Авто замын байгууламж	Зам	Замын хүчин чадал, авто машины эрчмийн судалгаа, замын өргөн, эгнээ, нийт урт, хүрэлцээ, төрлөөр ангилах, уулзвар, гүүр нүхэн гарцын байршил, хүчин чадлыг тодорхой гаргах
	Автобусны терминал	Хотын доторх автобусны буудал, хурдны автобусны буудал, автобусны автобусны зогсоол
	Авто замын хөдөлгөөн	Хотын доторх замын хөдөлгөөн, бүсийн замын хөдөлгөөн, ажил эхэлж тарах үеийн замын хөдөлгөөн, замын хөдөлгөөнд оролцож буй хүчин зүйлс бүрийг ангилах, машин техникийн ангиллаар замын хөдөлгөөний ачаалал, зорчигч тээвэрлэх замын хөдөлгөөн, ачаа тээврийн замын хөдөлгөөн
Олон нийтийн соёл урлаг, биеийн тамирын байгууламж	Сургалт, соёл урлагийн байгууламж	Сургууль, музей, олон нийтийн номын сан, урлагийн театр, нэгдсэн спортын талбай, иргэдийн хурал цуглааны байр
	Нийгэм халамжийн байгууламж	Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах газар
	Ашиглалтын өмнөх засаг захиргааны газар	Засаг захиргааны хяналтын байгууламж зэрэг улсын өмчит захиргааны байр
Орон зайн байгууламжууд	Цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын парк	Цэцэрлэгт хүрээлэн тус бүрийн байршил, талбай
	Ногоон байгууламж	Байгууламжуудын ногоон талбай, зориулалт
	Талбай, олон нийтийн газар	Талбай болон олон нийтийн газрын байршил, тоо ширхэг, талбай

Байгаль орчны үндсэн байгууламжууд	Агаарын бохирдол	Агаарыг бохирдуулагч бүрийн бохирдлын хэмжээ, зэрэг, бохирдлын эх үүсвэр /одоо ажиллаж буй жижиг дунд үйлдвэрлэл/ , одоо хэрэгжүүлж буй арга хэмжээ, яндангийн тоог гаргах
	Дуу чимээ, чичиргээ	Гол суурьшлын бүсүүдийн өдөр шөнийн дуу чимээ болон чичиргээний хэмжээ
	Усны бохирдол	Голын бохирдлын зэрэг, бохирдуулж буй эх үүсвэрүүдийг тодорхойлж жагсаалт гаргах, бохирдол үүсгэж буй хүчин зүйлүүдэд цаашид авах арга хэмжээг тодорхойлох
	Хөрсний бохирдол	Хөрсний бохирдолын хэлбэрүүд, хөрсний бохирдол үүсгэж буй хүчин зүйлүүдийн жагсаалт, цаашид шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох
	Хаягдал, бохир усны үүсгүүр	Ахуйн хэрэглээний бохир ус болон үйлдвэрийн бохир усаар нь тус бүрийн ялгаруулж буй бохир усны хэмжээ, цэвэрлэх чадамж, бохир ус дамжуулах хоолой, бохир ус зэрэг, бохир ус үүсгэгчийг тодорхойлж тоо хэмжээг гаргах
	Хог хаягдал/ хог хаягдлыг боловсруулах	Ахуйн хог хаягдал болон үйлдвэрийн хог хаягдал тус бүрийн ялгаруулж буй хогны одоогийн байдал, хогын цэг, хог тээвэрлэлтийн менежмент, цэвэрлэх байгууламжийн байршил болон хүчин чадлыг тодорхойлох, хог хаягдлыг ахуйн, үйлдвэрийн, аюултай зэргээр ангилан тодорхойлох
Хамгаалалтын байгууламж	Гол, урсгал устай газар болон тогтоц устай газар	Байршил ба
	Галын аюул, усны аюул, салхины аюул, хөрс шорооны аюулаас хамгаалах байгууламж	Байгууламжийн байршил ба тоо

ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫГ ХОТ БАЙГУУЛАЛТЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНД ХҮЛЭЭЖ АВАХАД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА

1. Мэдээллийн сангийн солбицлын тогтолцоо

Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоон зургийг WGS-84 солбицлын тогтолцооны UTM тусгагт хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай.

2. Мэдээллийн сангийн тоон зураг үүсгэх хэлбэр
   - Мэдээллийн санд хүлээлгэн өгч байгаа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоон зураг нь AutoCAD төрлийн программ дээр зурагдсан *.dwg өргөтгөлтэй, ArcGis төрлийн програм дээр зурагдсан *.gdb өргөтгөлтэй байна.
   - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоон зургийг зураглахдаа 1:1 харьцаагаар, зөвхөн polyline, polygon гэсэн шулууны төрлийг ашиглан гүйцэтгэнэ.
3. Мэдээллийн санд хүлээлгэн өгч байгаа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоон зургийн давхарга
   - ЕТ, ХЕТ-ний тоон зургийн давхаргын /Layer/ стандартын дагуу үүсгэнэ. /001,002,003,004,005, 006/
   - ЕТ, ХЕТ-ний барилга байгууламжийг зориулалтаар нь ангилан хүчин чадлыг бичсэн байна.
   - Байр зүйн дэвсгэр зургийг ерөнхий төлөвлөгөөний тоон зургийн суурь болгон ашиглахдаа байр зүйн зургийн батлагдсан заавар, стандартыг баримтлана.
4. Мэдээллийн санд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоон зураг хүлээлгэн өгөх
   - ЕТ, ХЕТ-ний өнгөт зураг, ерөнхий харагдах байдлын зургийг, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн ерөнхий төлөвлөгөөний зураг болон 3-н хэмжээст зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгнө. /AutoCad, Sketch UP, 3dmax файл байх, CD-нд хуулах/
   - ЕТ, ХЕТ-ний төлөвлөлтийн онцлогийг харуулсан 2 минутаас багагүй хугаацаатай анимэйшн хүлээлгэн өгнө.
   - ЕТ, ХЕТ-г зөвшөөрөлцсөн, баталсан албан тушаалтны гарын үсэг болон зураг хийж гүйцэтгэсэн компанийн тамга, гарын үсэгтэй хэвлэмэл зургийн хамт өгнө.
   - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний товч танилцуулга /*.doc/
   - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга /*.power point/.

Жич: ЕТ, ХЕТ-ны тоон зургийг хүлээн авсан мэргэжилтэн стандартын дагуу хийж гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж, шаардлага хангасан тохиолдолд зураг хүлээн авсан акт үйлдэж өгнө.

БАЙР ЗҮЙН ЗУРГИЙН ДАВХАРГЫН ШААРДЛАГА

/Хүснэгт-1/

Д/д	layer-ийн бичиглэл	Тайлбар	Color /Өнгө/	Linetype /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
1	1	Байшин, барилга	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
2	2	Байшин, барилгын пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
3	3	Хатуу цэгийн өндрийн бичиглэл	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	306 1284. 26 1.0
4	4	Газар дээрх холбооны шугам	Magenta /үндсэн ягаан/	continuous /үргэлжилсэн/	0.00	
5	5	Газар доорх холбооны шугам	Magenta /үндсэн ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
6	6	Холбооны худаг	Magenta /үндсэн ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0
7	7	Газар доорх цахилгааны өндөр хүчдлийн шугам	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
8	8	Газар доорх цахилгааны нам хүчдлийн шугам	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
9	9	Гэрлийн шон	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	0.7 1.8
10	11	Хашааны пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
11	12	Дулааны шугам	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
12	13	Дулааны худаг	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0
13	14	Гол	Blue /үндсэн хөх/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
14	15	Голын пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
15	16	Ухсан нүх, овоолсон шорооны ирмэг	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	

Д/д	layer-ийн бичиглэл	тайлбар	Color /Өнгө/	Linetype /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
16	17	Ухсан нүх, овоолсон шорооны ирмэгийн пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
17	18	Насип	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
18	19	Насипын пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
19	20	Хоолой	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
20	21	Мод	Green /үндсэн ногоон/	Continuous /үргэлжилсэн/	0.00	0.8 1.5
21	23	Кабелийн TV-ийн төв шугам	Red /үндсэн улаан/	Dashed /тасархай/	0.00	
22	24	Кабелийн TV-ийн туслах шугам	Red /үндсэн улаан/	Dashed /тасархай/	0.20	
23	25	Зам, талбай	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
24	26	Зам, талбайн пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
25	27	Бохирын шугам	Green /үндсэн ногоон/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
26	28	Бохирын шугамын худаг	Green /үндсэн ногоон/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0
27	29	Цэврийн шугам	Blue /үндсэн хөх/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
28	30	Цэврийн шугамын худаг	Blue /үндсэн хөх/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0
29	31	Ус зайлуулах хоолой	Cyan /үндсэн цэнхэр/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
30	32	Ус зайлуулах хоолойн худаг	Cyan /үндсэн цэнхэр/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0

Д/д	layer-ийн бичиглэл	тайлбар	Color /Өнгө/	Linetype /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
31	35	Бензин клонкийн шугам	Magenta /үндсэн ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
32	36	Бензин клонкийн шугамын худаг	Magenta /үндсэн ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1.0
33	37	Төмөр зам	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	2.5
34	38	Төмөр замын пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
35	40	Бүх текстэн бичиглэл	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	2.0 Контор
36	41	Дижитайзердсан цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
37	45	Планшетний хүрээ	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
38	46	Улаан шугамны хүрээ	red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
39	50	Үргэлжилсэн рельеф	Brown /өнгө 32/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
40	51	Үндсэн рельеф	Brown /өнгө 32/	Continuous /үргэлжилсэн/	0.30	
41	59	Барилга байшингийн дугаар	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	2.5 2/1а
42	62	Пикет цэг	White /үндсэн цагаан/	Dot /цэгэн/	0.00	
43	63	Өндрийн цэгийн бичиглэл	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	2.5 1282,35
44	64	Тор	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	

Д/д	layer-ийн бичиглэл	тайлбар	Color /Өнгө/	Linetype /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
45	65	Цэврийн шугамын өндрийн бичиглэл	Blue /үндсэн хөх/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1290.78 - худгийн өндөр 1290.74 - газрын өндөр 1288.50 - трубаны өндөр 1287.98 - ёроолын өндөр
46	66	Дулааны шугамын өндрийн бичиглэл	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1291.65 - худгийн өндөр 1291.65 - газрын өндөр 1289.85 - трубаны өндөр 1287.85 - ёроолын өндөр
47	67	Бохирын шугамын өндрийн бичиглэл	Green /үндсэн ногоон/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1290.92 - газрын өндөр 1289.30 - ёроолын өндөр 1288.10 - хоолойн өндөр
48	68	Холбооны шугамын өндрийн бичиглэл	Magenta /үндсэн ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	1291.83 - газрын өндөр 1291.83 - кабелын өндөр 1290.33 - ёроолын өндөр
49	69	Үерийн далан, сувгийн өндрийн бичиглэл	Cayn /үндсэн цэнхэр/	Continuous /үргэлжилсэн/	0.00	- худгийн өндөр - газрын өндөр - трубаны өндөр - ёроолын өндөр
50	70	Өндөр хүчдлийн агаарын шугам	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
51	71	Нам хүчдлийн агаарын шугам	Red /үндсэн улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
52	72	Өндөр хүчдэлийн цамхаг	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
53	73	Хөшөө	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
54	74	Гүүр	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
55	100	Бетон хашаа	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
56	101	Модон хашаа	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
57	102	Төмөр хашаа	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
58	103	Хайсан хашаа	White /үндсэн цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	

Auto CAD програмын ЕТ, ХЕТ-ний давхаргын стандарт

/Хүснэгт-2/

д/д	Томъёолсон дүрслэл, тэмдэглэгээ	Тэмдэглэгээний нэрс	LAYER -ын дугаар	LAYER -ын тодорхойлолт		Тайлбар
				өнгө	өргөн	
1		Одоо байгаа барилга байгууламж	1001	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн өргөн зураас, үргэлжилсэн нарийн зураас
				цагаан	0.30	
				Туслах зураас		
				цагаан	LINE	
2		Төлөвлөж буй барилга, байгууламж	1002	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн өргөн зураас, үргэлжилсэн нарийн зураас
				цагаан	0.40	
				Туслах зураас		
				30	SOLID	
3		Буулгах барилга	1003	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Тасалдсан үндсэн өргөн зураас, хэрэгсэгдэй
					0.20	
4		Өргөтгөл	1004	Туслах зураас		
5		Дан барилга	1005	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Стандартын дагуу
				253	0.20	
6		Давхар барилга		Туслах зураас		
7		Төлөвлөж буй автозам, талбай	1006	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Үргэлжилсэн өргөн зураас
				цагаан	0.35	
		Зогсоолын тэмдэглэл	1007	Туслах зураас		
					SOLID	
8		Явган хүний жижиг, том хавтан	1008	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Торон зураас
				цагаан	0.18	
				Туслах зураас		
				27	NET	
9		Явган хүний гарц	1009	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Ташуу зураас
				цагаан	0.18	
				Туслах зураас		
				27	ANSI31	
10		Төлөвлөгдөж буй ногоон суулгамал, мод	1010	Үндсэн зураас		MNS ISO128-20:2003
				цагаан	0.18	
				Туслах зураас		
				84	GRASS	
11		Төлөвлөж буй гадна шат	2001	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Үргэлжилсэн үндсэн нарийн зураастай байна.
					0.20	
12		Төлөвлөж байгаа хашаа, хязгаар	2002	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Үргэлжилсэн үндсэн нарийн зураас
				200	0.20	
13		Гудамж талбайн гэрэлтүүлэг	2003	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Дугуй дүрс, нарийн зураастай байна.
				16	0.20	
14		Дурсгалын хөшөө Баримал	2004	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Хагас дугуй зүрс, үргэлжилсэн нарийн зураас, нэг талыг нь харлуулна.
				28	0.20	
15		Төлөвлөж буй амралт спортын талбай	2006	Үндсэн зураас		
				108	0.20	
				Туслах зураас		
16		Text	2007	style 2 - текст бичих төрөл		
				цагаан	0.20	
				Arial Mon - формат		
				Өндөр	2 cm	

д/д	Томъёолсон дүрслэл, тэмдэглэгээ	Тэмдэглэгээний нэрс	LAYER -ын дугаар	LAYER -ын тодорхойлолт		Тайлбар
				өнгө	өргөн	
17		Төлөвлөж буй төмөр зам	2008	Үндсэн зураас		Өндөрлөсөн ба ухсан газар байгаа төмөр зам өндөрлөсөн ба ухсан газрын дэд болон доод ирмэг нь үргэлжилсэн нарийн зураастай байна.
					0.20	
				Туслах зураас		
18		Хүрээ, хүрээний бичэглэл	2009	Үндсэн зураас		
				цагаан	0.20	
				Туслах зураас		
				style 2 - текст бичих	Arial Mon - формат	
19		Төлөвлөж буй тулгуур хана	3001	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн өрөн, зураас, үргэлжилсэн нарийн зураастай байна.
				192	0.20	
20		Төлөвлөж буй налуу газар	3002	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн нарийн зураастай байна.
				192	0.20	
21		Төлөвлөж буй ил шуудуу	3003	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн нарийн зураастай байна.
				192	0.20	
22		Төлөвлөж буй далд шуудуу	3004	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 үргэлжилсэн үндсэн нарийн зураастай байна.
				192	0.20	
23	14.40 14.00	Өндөржилтийн цэг	3005	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Заалт шугам Хүртвэрт төлөвлөсөн өндөр Хуваарьт одоо байгаа өндөр
				цагаан	0.20	
24	0.004 55.00 налуу% Усны урсах холын зай	налуу	3006	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 0.004- Налуу /%/ Сумтай зураас -Усны урсах чиг 55.00- Холын зай /м/
				цагаан	0.20	
25		Төлөвлөж буй улаан газрын гадрага, хаялбар	3007	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Газрын гадаргын хаялбарын шугам үргэлжилсэн өрөн нарийн зураастай байна.
				55	0.20	
26		Нэмэх шороо	4001	Үндсэн зураас		MNS ISO128-20:2003 /+/ - нь нэмэх шороог заана.
				30	0.20	
27		Хасах шороо	4002	Үндсэн зураас		MNS ISO128-20:2003 /-/ - нь хасах шороог заана.
				30	0.20	
28	+0.45	Ажлын өндөр	4003	Үндсэн зураас		MNS ISO128-20:2003 +0.45 - өндрийн хэмжээ Солбилцсон нарийн зураас
				30	0.20	
29	17 4R0	Ажлын хэмжээ	4004	Үндсэн зураас		10 мм диаметртэй тойрог хүртвэрт хасагдах, нэмэгдэх шороony хэмжээ /мкуб/ Хуваарьт талбайн хэмжээ /мкв/
				30	0.20	
30		Нойл шугам	4005	Үндсэн зураас		MNS ISO128-23:2003 Тасалдсан өрөн зураас
				30	0.20	
31	1.0 0.2	Газар доорхи өндөр хүчдлийн шугам	5001	Үндсэн зураас		MNS 3757-16:2007 "Цахилгаан тоног төхөөрөмж, дамжуулагчийн таних тэмдэглэгээ"
				улаан	0.20	
32	1.0 0.2	Газар доорхи нам хүчдлийн шугам	5002	Үндсэн зураас		MNS 3757-16:2007 "Цахилгаан тоног төхөөрөмж, дамжуулагчийн таних тэмдэглэгээ"
				улаан	0.20	
33		Төлөвлөж буй цахилгааны дэд өртөө	5003	Үндсэн зураас		MNS 3757-16:2007 Тухайн барилгын хэмжээ, үргэлжилсэн нарийн зураастай байна.
				улаан	0.20	
34	0.2	Цахилгааны худаг	5004	Үндсэн зураас		MNS ISO128-23:2004 Үргэлжилсэн нарийн зураастай байна.
				улаан	0.20	
35	1.0 0.2	Цахилгааны агаарын шугам	5005	Үндсэн зураас		MNS 3757-16:2007 "Цахилгаан тоног төхөөрөмж, дамжуулагчийн таних тэмдэглэгээ"
				улаан	0.20	
36	0.2	Холбооны худаг	5006	Үндсэн зураас		MNS-4908 :2000 Телефоны сүлжээний таних тэмдэглэгээ
				улаан	0.20	
37		Газар доорх холбооны шугам	5007	Үндсэн зураас		MNS-4908 :2000 Телефоны сүлжээний таних тэмдэглэгээ
				улаан	0.20	
38	0.1 1.0	Холбооны агаарын шугам	5008	Үндсэн зураас		MNS-4908 :2000 Телефоны сүлжээний таних тэмдэглэгээ
				улаан	0.20	

д/д	Томъёолсон дүрслэл, тэмдэглэгээ	Тэмдэглэгээний нэрс	LAYER -ын дугаар	LAYER -ын тодорхойлолт		Тайлбар
				өнгө	өргөн	
39	ЦТП	Дулаан дамжуулах төв	6001	Үндсэн зураас ягаан	0.20	MNS ISO 128-23 :2004 Тухайн барилгын хэмжээ, үргэлжилсэн нарийн зураас цтп - жижиг үсгээр
40		Дулааны өргөлтийн насос станц	6002	Үндсэн зураас улаан	0.20	MNS ISO 128-23 :2004 Дугуй дүрс, нарийн зураастай байна.
41	0.2	Дулааны худаг	6003	Үндсэн зураас улаан	0.20	MNS ISO 128-23 :2004 Үргэлжилсэн нарийн зураастай байна.
42		Дулааны шугам	6004	Үндсэн зураас улаан	0.20	MNS 5213 :2002 Дамжуулах хоолойн томъёолсон ба таних тэмдэглэгээтэй байна.
43		Бохир усны насос станц	6005	Үндсэн зураас ногоон	0.20	MNS 5213 :2002 Дамжуулах хоолойн томъёолсон ба таних тэмдэглэгээтэй байна.
44	0.2	Бохир усны худаг	6006	Үндсэн зураас ногоон	0.20	
45	Д Д	Бохир усны шугам Даралттай бохир усны шугам	6007	Үндсэн зураас ногоон	0.20	MNS 5213 :2002 Дамжуулах хоолойн томъёолсон ба таних тэмдэглэгээтэй байна.
46		Бохир усны цооног	6008	Үндсэн зураас ногоон	0.20	
47		Цэвэр усны насос станц	7001	Үндсэн зураас хөх	0.20	
48	0.2	Цэвэр усны худаг	7002	Үндсэн зураас хөх	0.20	
49		Цэвэр усны шугам	7003	Үндсэн зураас хөх	0.20	MNS 5213 :2002 Дамжуулах хоолойн томъёолсон ба таних тэмдэглэгээтэй байна.
50	0.2	Цэвэр усны гүний худаг	7004	Үндсэн зураас хох	0.20	
51	0.2	Цэвэр усны усан сан	7005	Үндсэн зураас хох	0.20	
52	0.2	Борооны ус зайлуулах хоолойн худаг	7006	Үндсэн зураас цэнхэр	0.20	
53	Y	Борооны ус зайлуулах хоолой	7007	Үндсэн зураас цэнхэр	0.20	
54		Бусад	7008	Үндсэн зураас 207	0.20	Авто машин, тоглоомын талбай зэрэг чимэглэлийн элементүүдийг зурна.